



**ХЭРЛЭН ГОЛЫН САВ ГАЗАРТ
ХАМААРАХ СҮХБААТАР АЙМГИЙН
МӨНХХААН, ТҮМЭНЦОГТ, СҮХБААТАР
СУМДЫН УСТ ЦЭГИЙН БҮРТГЭЛ,
ТООЛЛОГЫН АЖЛЫН ТАЙЛАН**

2024



**СҮХБААТАР АЙМГИЙН МӨНХХААН,
ТҮМЭНЦОГТ, СҮХБААТАР СУМДЫН
2024 ОНЫ УСТ ЦЭГИЙН БҮРТГЭЛ,
ТООЛЛОГЫН АЖЛЫН ТАЙЛАН**

Оролцсон:

Түмэнцогт сум: Г.Энхтуяа /Сумын Засаг дарга/, Г.Алтанхуяг, Ц.Шарав-Очир,
Х.Өлзийдэлгэр, М.Намхайдорж /Багийн Засаг дарга/, Б.Элбэгшүр /БОХУБ/

Сүхбаатар сум: Э.Амгаланбаяр /ЗДТГ-ын дарга/, Э.Өлзийбаатар, С.Гандөлгөөн
/Багийн Засаг дарга/, Н.Буянхишиг /ХАА мэргэжилтэн/, С.Ганбулган /БОХУБ/

Мөнххаан сум: З.Гэрэлцэцэг /БОХУБ/, М.Энхболд /ХХА-н мэргэжилтэн/, Ч.Ууганбаяр
/Багийн Засаг дарга/

Сүхбаатар аймаг БОАЖГ: Б.Болортунгалаг /Усны нөөцийн ашиглалт, хамгаалалт
хариуцсан мэргэжилтэн/

Хэрлэн голын сав газрын захиргаа: Ч.Сайнбаяр /Газарзүйн мэдээлэл, усны
мэдээллийн дэд сан хариуцсан мэргэжилтэн, У.Жамбалдагва /Газрын доорх усны
нөөц, хяналт шинжилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн/, Д.Баярхүү /жолооч/

**Өмнөх үг**

Монгол улсын “Усны тухай” хуульд Сав газрын захиргаадыг байгуулж, тэдгээрийн эрх үүргийг хуульчилж өгсөн нь Үндэсний аюулгүй байдлын хэмжээнд хүртэл анхаарал татах болсон усны асуудлыг олон улсын жишгээр сав газрын менежментийн зарчмын дагуу хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлсэн,.

2004 оны Усны тухай хуулиар усны тоо бүртгэлийг ажлыг Усны асуудал эрхэлсэн Засгийн газрын эрх бүхий байгууллага 4 жил тутам улсын хэмжээнд зохион байгуулдаг байсан бол 2012 оны шинэчлэн батлагдсан хуульд Сав газрын захиргаа жил бүр тухайн сав газрын хэмжээнд нутгийн захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнахаар заажээ.

Энэхүү ажлын зорилго нь усны сан бүхий газар, ус хангамжийн эх үүсвэрийн тоо хэмжээ, усны барилга байгууламж, ус хэрэглэгч, ашиглагчдын тоо бүртгэлийг явуулж, сав газрын хэмжээн дэх усны нөөц, чанарын өөрчлөлт, ус хэрэглээ, ашиглалттай холбоотой мэдээ, тайлан гаргах, аймаг, нийслэл, сум, дүүрэг болон салбар дундын усны ашиглалт, хамгаалалт, хуваарилалтыг зохицуулах, ус хуримтлуулах, талаар авах арга хэмжээг төлөвлөх, улсын болон сав газрын усны мэдээллийн дэд санг баяжуулж, олон нийтийг мэдээллээр хангахад оршино.

Сүхбаатар аймгийн Мөнххаан, Түмэнцогт, Сүхбаатар сумдын 2024 оны усны тоо бүртгэлийн тайлан нь 3 үндсэн бүлэг, 6 хавсралт, 5 хүснэгт, 9 зургаас бүрдэнэ. Тайлангийн нэгдүгээр бүлэгт усны тоо бүртгэл явуулах ажлын үндэслэл, зохион байгуулалт, аргазүй, аргачлал, хоёр дугаар бүлэгт бэлтгэл болон хээрийн ажил, суурин боловсруулалт, гуравдугаар бүлэгтүр дүн гэсэн сэдвүүдийг тусгаж, зураг, хүснэгтээр усны сан бүхий газар, ус хангамжийн эх үүсвэр, ус хэрэглэгч, ашиглагчдын талаарх мэдээллийг илэрхийлсэн.

Усны тоо бүртгэлийн ажлыг Хэрлэн голын Сав Газрын Захиргааны 4 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг гэрээнд заасан хугацаанд сумдад очиж ажлын удирдамжын чиг үүрэг, маршрутыг орон нутгий удирдлага, холбогдох мэргэжилтэй байцаагч, багийн Засаг дарга нарыг байлцуулан хэлэлцэж шийдвэрлэж, орон нутгийн оролцоотойгоор зохион байгуулж ажила лаа.

Усны тоо бүртгэлийн ажлыг явуулахад идэвх санаачлагатай оролцож, хамтран ажилласан орон нутгийн удирдлага, ард иргэд, байгаль хамгаалагч, БОХУБ нартаа чинь сэтгэлийн талархал илэрхийлье.

ХЭРЛЭН ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ
ДАРГА Б.НАНДИНЦЭЦЭГ



Гарчиг

Өмнөх үг.....	3
Нэгдүгээр бүлэг: Ерөнхий зүйл	4
1.1. Үндэслэл	4
1.2. Зохион байгуулалт.....	4
Хоёрдугаар бүлэг: Үйл ажиллагаа	5
2.1. Бэлтгэл ажил.....	5
2.2. Хээрийн ажил.....	5
2.3. Суурин боловсруулалт.....	7
Гуравдугаар бүлэг: Үр дүн	7
3.1. Гол горхи.....	7
3.2. Нуур тойром	9
3.3. Булаг шанд	12
3.4. Худаг	16
3.5. Ус ашиглагчид.....	20
Дүгнэлт	21
Хавсралт 1. Сүхбаатар аймгийн Засаг даргын захирамж	23
Хавсралт 2. Усны тоо бүртгэлийн ажил гүйцэтгэх гэрээ	24
Хавсралт 3. Хэрлэн голын сав газрын захиргааны даргын баталсан ажлын удирдамж	27
Хавсралт 4. Мөнххаан сумын уст цэгийн тоо бүртгэлийн дүн	28
Хавсралт 5. Түмэнцогт сумын уст цэгийн тоо бүртгэлийн дүн	33
Хавсралт 6. Сүхбаатар сумын уст цэгийн тоо бүртгэлийн дүн.....	38



Нэгдүгээр бүлэг: Ерөнхий зүйл

1.1. Үндэслэл

Монгол улсын “Усны тухай” хуулийн 7.3, 17.1.4, 18 дугаар зүйлийн 18.1.5 дахь заалт, Сүхбаатар аймгийн Засаг даргын 2024 оны 08-р сарын 28-ны өдрийн А/507 дугаартай “Усны тоо бүртгэл явуулах тухай” захирамж, Сүхбаатар аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар болон Хэрлэн голын сав газрын захиргаадын хооронд байгуулсан усны тоо бүртгэлийн ажил гүйцэтгэх 02 дугаар гэрээ, Хэрлэн голын сав газрын захиргааны даргын баталсан ажлын удирдамжийн дагуу усны тоо бүртгэлийн ажлыг зохион байгуулах.

1.2. Зохион байгуулалт

Хэрлэн голын сав газрын захиргааны даргын баталсан ажлын удирдамжийн дагуу “Усны тоо бүртгэлийг хариуцан явуулах ажлын хэсэг”-ийг байгуулж, дор дурдсан хугацаанд усны тоо бүртгэлийн ажлыг 3 үе шаттай явуулахаар зохион байгуулсан. Үүнд:

1. Бэлтгэл ажил (Х/01 – Х /14);
2. Хээрийн ажил (Х/14 – Х /26);
3. Суурин боловсруулалт (Х /28– ХI/15)

Усны тоо бүртгэлийг хариуцан явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Үүнд:

1. Сүхбаатар аймгийн БОАЖГ-ын усны мэргэжилтэн Б.Болортунгалаг
2. Газарзүй мэдээллийн систем усны мэдээллийн дэд сан хариуцсан мэргэжилтэн Ч.Сайнбаяр
3. Газрын доорх усны нөөц, ашиглалт хариуцсан мэргэжилтэн У.Жамбалдагва
4. Нярав жолооч Д.Баярхүү

Сумдаас усны тоо бүртгэлийн ажилд дараах төлөөллүүдтэй хамтран ажилласан.

Мөнххаан сум: З.Гэрэлцэцэг /БОХУБ/, М.Энхболд /ХХА-н мэргэжилтэн/, Ч.Ууганбаяр /Багийн Засаг дарга/

Түмэнцогт сум: Г.Энхтуяа /Сумын Засаг дарга/, Г.Алтанхуяг, Ц.Шарав-Очир, Х.Өлзийдэлгэр, М.Намхайдорж /Багийн Засаг дарга/, Б.Элбэгшүр /БОХУБ/

Сүхбаатар сум: Э.Амгаланбаяр /ЗДТГ-ын дарга/, Э.Өлзийбаатар, С.Гандөлгөөн /Багийн Засаг дарга/, Н.Буянхишиг /ХАА мэргэжилтэн/, С.Ганбулган /БОХУБ/

Дээрх сумдын болон сав газарт хамаарах талбай, эзлэх хувийг Хүснэгт 1-д үзүүлэв.

Хүснэгт 1. Усны тоо бүртгэл явуулсан сумдын засаг захиргааны нэгж

№	Аймаг,	Сум,	Нийт талбай, км ²	Сав газарт хамаарах талбай, км ²	Сав газарт эзлэх хувь, %
1	Сүхбаатар	Мөнххаан	7450,0	3719,4	49,9
2		Түмэнцогт	2173.1	2173.1	100
3		Сүхбаатар	12875.2	5496.1	42,7



Хоёрдугаар бүлэг: Үйл ажиллагаа

2.1. Бэлтгэл ажил

Усны тоо бүртгэлийн ажлыг зохион байгуулж, үнэн зөв, бодитой үр дүнд хүрэхийн тулд бэлтгэл ажлыг сайтар хангах нь чухал юм. Үүний тулд бидний зүгээс нэн тэргүүнд усны тоо бүртгэлийг явуулах тухай Сүхбаатар аймгийн засаг даргын захирамжийг гаргуулж ажлын дэс дараалал, хугацаа, санхүүжилтийн хуваарь зэргийг сав газрын онцлогт тохируулан нарийвчлан тусгаж БОАЖГ-тай гэрээ байгуулсан.

Дээрх захирамжийг үндэслэн усны тоо бүртгэлийг хариуцан явуулах ажлын хэсгийг байгуулж, удирдамжийг Хэрлэн голын сав газрын захиргааны даргаар баталгаажуулан явах сумдын 2020 оны уст цэгийн мэдээллийн хүснэгт болон уст цэгийн тооллогын зургийг хэвлүүлж GPS, зөөврийн компьютер, туузан метр, усны хатуулаг болон захилгаан дамжуулах чадвар хэмжих гар төхөөрөмж, зургийн аппарат зэрэг багаж хэрэгслүүдийг зэхэж бэлтгэл ажлыг хангасан.

2.2. Хээрийн ажил

Хэрлэн голын сав газрын усны тоо бүртгэл явуулах бүрэлдэхүүн 2024 оны 10 сарын 14-ны өдрөөс батлагдсан удирдамж, аргазүйн дагуу хээрийн ажлыг эхлүүлсэн.

Ажлын хэсэг хариуцсан сумдын удирдлагуудад Сүхбаатар аймгийн Засаг даргын захирамж, ажлын удирдамжийг танилцуулан, газар нутаг, уст цэгийн байрлалыг сайн мэдэх сумын төлөөллийг (багийн засаг дарга, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч... гм) томилуулж усны тоо бүртгэлийн ажлыг зохион байгуулсан.

Тухайн сумын газар нутгийн онцлог, уст цэгүүдийн байршил, сав газарт эзлэх хувь хэмжээнээс хамаарч уст цэгийн байршлыг ажлын зураг дээр тодорхойлж, “Усны тоо бүртгэл явуулах ажлын аргазүй, үлгэрчилсэн заавар”-т заасны дагуу ажилласан.



Зураг 1. Орон нутгийн төлөөллүүдтэй усны тоо бүртгэлийн ажлыг танилцуулж ярилцаж байна

Тухайлбал, бүх уст цэгүүд болон усны барилга байгууламж, ус ашиглагчдын талаарх ерөнхий мэдээлэл, тухайн газар нутгийн нэр, онцлогийг аман судалгаагаар тодруулж, газарзүйн байршлыг GPS багаж дээр буулгаж, фото зургаар баталгаажуулан зарим нэг булаг шанд, худаг усан дахь усны эрдэсжилт ба хүчил, шүлтийн агууламжийг рН метр болон усны цахилгаан дамжуулах чадвар тодорхойлогч багажны тусламжтай тодорхойлсон.



Зураг 2. Усны чанарын ерөнхий үзүүлэлтийг тодорхойлж байна




Зураг 3. Газрын зураг дээр ажиллаж худаг уст цэгийн байршил тодорхойлж байна

Зарим худаг, уст цэгийн нэршил тодорхойгүй байсныг энэ сумын төлөөлөл, малчид, иргэдээс сурвалжлан нэршлийг тогтоосон.



2.3. Суурин боловсруулалт

Хээрийн ажлаар бүрдүүлсэн бүх мэдээ, материалыг нэгтгэх, боловсруулах, дүн шинжилгээ хийх, тэдгээрийг зурагт буулгах, үр дүнг боловсруулах ажлуудыг суурин боловсруулалтын хүрээнд гүйцэтгэлээ.



Зураг 4. Хээрийн ажлын үр дүнг нэгтгэж боловсруулалт хийж байна.

Гуравдугаар бүлэг: Үр дүн

Усны тоо бүртгэлийн хээрийн ажлын хүрээнд бүрдүүлсэн мэдээ, мэдээллийг боловсруулж, Microsoft excel программд ангилан оруулж, сав газрын усны мэдээллийн дэд санг баяжуулсан. Дээрх тоон мэдээллийг газарзүйн мэдээллийн систем ArcGIS программ хангамж руу хөрвүүлж, үр дүнг гол горхи, нуур тойром, булаг шанд, рашаан, худаг гэсэн сэдэвчилсэн зургаар илэрхийлж тэдгээрийг Сүхбаатар аймгийн БОАЖГ-т цахим хэлбэрээр хэвлэмэл тайлангийн хамт хүргүүлээ.

3.1. Гол горхи

Сүхбаатар аймгийн усны тоо бүртгэл явуулсан сумдад 1 гол буюу Хэрлэн гол Түмэнцогт сумын нутагт тоологдсон.

Хэрлэн гол:

Номхон далайн ай савын гол мөрөн дотор уртын хэмжээгээр тэргүүн байранд ордог. Их Хэнтий нурууны өвөр бэлээс эх авч урсах Богдын гол, Цагаан гол хоёрын уулзварыг Хэрлэн голын эх гэж үзнэ. Хэрлэн гол нь Төв, Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймаг, Багануур дүүргийн нутгийг дамжин 1090 км урсаж улсын хилээс гадагш гарч БНХАУ-ын Далай нуурт цутгадаг Монгол орны томоохон голын нэг юм. Ус хурах талбай нь сав газрын хэмжээнд 107906 км²



бөгөөд Дорнод аймгийн хувьд 37'974 км² бөгөөд энэ нь сав газрын 35,2%-ийг эзлэх ба усны дундаж уналт километр тутамд 1,2 метр болно. Голын нийт уртын голдрилын өргөн, гүн, урсгалын хурд ихээхэн ялгаатай байна. Эхэн хэсэгт голдрилын өргөн 30-50 м байдаг бол дунд, адаг хэсэгт 150-200 м болж 0,8-1,5 метрийн гүн зонхилно.

3.2. Нуур тойром

Усны тоо бүртгэл явуулсан сумдад нийт 26 нуур тойром тоологдсон бөгөөд Мөнххаан - 4, Түмэнцогт- 14, Сүхбаатар – 8 байна.




Зураг 5. Зарим булаг шандын фото зураг




Хүснэгт 2. Сүхбаатар аймгийн тоо бүртгэл явуулсан сумдын нуур тойрмын тоон мэдээлэл


№	Сумын нэр	устай	усгүй	Нийт
2020				
1	Мөнххаан	4	-	4
2	Түмэнцогт	7	7	14
3	Сүхбаатар	7	1	8
2024				
1	Мөнххаан	4	-	4
2	Түмэнцогт	14	-	14
3	Сүхбаатар	8	-	8
Үүнээс				26
Байнгын устай, хур борооны усаар тэжээгддэг		4		
Тухайн жилийн хур борооноос шалтгаалж ширгэдэг улиралын чанартай		22		
ДҮН		26		



Зураг 6. Мөнххаан сум нуурын байршлын зураг



Зураг 7. Сүхбаатар сум нуурын байршлын зураг.



Зураг 8. Усны тоо бүртгэл явуулсан сумдын нуурын байршлын зураг



3.3. Булаг шанд

Усны тоо бүртгэл явуулсан сумдад нийт 21 булаг шанд тоологдсон бөгөөд Мөнххаан – 7, Түмэнцогт-2, Сүхбаатар -13 байна.

Сав газрын хэмжээнд уур амьсгалын өөрчлөлт, хүний буруутай үйл ажиллагаа, орчны бохирдол, эх ундаргыг хамгаалаагүйгээс мал ихээр орох зэргээр бохирдож, ундарга нь багасч хатаж ширгэж байгаа булгууд цөөнгүй байна.

Хээрийн ажлын хүрээнд бүрдүүлсэн мэдээ, мэдээллийг нэгтгэн, боловсруулалт хийхэд тоо бүртгэл явуулсан сумдад нийт 21 булаг тоологдсоноос устай нь 20 ширгэсэн 2 хашиж хамгаалсан 3 (хашааг завралж сэргээх эсвэл шинээр хаших), хамгаалалтгүй 20 булаг шандын эхийг хашиж хамгаалж тохижуулах шаардлагатай байна.




Зураг 9. Зарим булаг шандын фото зураг




Хүснэгт 3. Усны тоо бүртгэл явуулсан сумд дахь булаг, шандны тоон мэдээлэл

Он	Д/д	Сумын нэр	Булаг, шанд				
			Устай	Ширгэсэн	Нийт	Хамгаалалт-тай	Хамгаалалт-гүй
2020	1	Мөнххаан	7	1	8	1	7
	2	Түмэнцогт	2	-	2	1	1
	3	Сүхбаатар	8	2	10	1	9
Нийт			17	3	20	3	17
2024	1	Мөнххаан	9	-	9	0	9
	2	Түмэнцогт	2	-	2	1	1
	3	Сүхбаатар	10	-	10	1	9
Нийт			21	-	21	2	20


Эдгээр тоон мэдээллийг газарзүйн мэдээллийн систем ArcGIS программ ашиглан үр дүнг зургаар илэрхийлэхдээ сав газраар болон сумаар үзүүлэв.



Зураг 10. Мөнххаан сум булгийн байршлын зураг




Зураг 11. Түмэнцогт сум булгийн байршлын зураг.



Зураг 12. Мөнххаан сум будаг шандны байршлын зураг

3.4. Худаг

Усны тоо бүртгэл явуулсан сумдын сумын төвүүдэд хүн амын ус хангамжийн зориулалтаар нийт 6 худаг ашиглаж байна.



Зураг 14. Түмэнцогт сум худгийн хориглолт хязгаарлалтын бүсийн зураг.


Усны тоо бүртгэл явуулсан сумдад нийт 552 худаг тоологдсон бөгөөд Мөнххаан- 176, Түмэнцогт – 191 , Сүхбаатар -185 худаг бүргэгдсэн байна.




Зураг 15. Зарим хуудгуудын фото зураг

Хүснэгт 4. Усны тоо бүртгэл явуулсан сумдын худгийн дэлгэрэнгүй мэдээлэл


№	Сумын нэр	Худаг		
		Өрөмдмөл	Гар худаг	Нийт худаг
2020 онд				
1	Мөнххаан	69	91	160
2	Түмэнцогт	73	103	176
3	Сүхбаатар	41	129	171
НИЙТ		183	323	506
2024 онд				
1	Мөнххаан	77	99	176
2	Түмэнцогт	79	112	191
3	Сүхбаатар	50	135	185
НИЙТ		206	346	552



Зураг 16. Сүхбаатар сум худгийн байршлын зураг



Зураг 17. Түмэнцөгт сум худгийн байршлын зураг



Зураг 18. Усны тоо бүртгэл явуулсан сумдын худаг уст цэгийн байршлын зураг

3.5. Ус ашиглагчид

Ус ашиглагчдын тоо бүртгэлийг ашиг олох зорилгоор усны нөөц ашиглан үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудын хүрээнд явуулсан.

Хамаарагдах сумдад аж ахуйн нэгж байгууллагууд ихэвчлэн төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрээс усаар хангагдаж байна.

Усны тоо бүртгэл явуулсан Сүхбаатар аймгийн Мөнххаан, Түмэнцогт, Сүхбаатар сумдын Хэрлэн голын сав газарт хамаарах нутаг дэвсгэрт уул уурхай болон газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа нийт 9 ус ашиглагч байна.



Дүгнэлт

1. “Усны тухай хууль”-ийн 7 дахь хэсэг 7.3 дахь заалтын хүрээнд жил бүр уст цэгийн усны тоо бүртгэлийн ажлыг зохион байгуулж, мэдээллийг аймаг, сумын хэмжээнд гаргаж байх.

2. Газар нутгийн онцлогоос хамаарч хөдөөний малчид гар худаг ихээр гаргаж байна. Тухайн худгийн гүн 2-10 метрийн гүнтэй голдуу хөрсний өнгөн хэсгийн усыг унд ахуйдаа хэрэглэж байгаа нь хөдөөгийн хүн амын ундны усан хангамжийн хүрэлцээ, эрүүл мэнд болоод усны чанарын шаардлага хангахгүй байна. Иймд малчдын усны эх үүсвэрийг тогтоох, чанарын шаардлага хангасан ундны усны эх үүсвэртэй болгох арга хэмжээг шат дараалалтайгаар авч хэрэгжүүлэх.

Энэхүү тооллогын явц, дүгнэлтийг үндэслэн сум орон нутгийн удирдлагуудад дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

- Сумын төвийн ундны усны худгуудыг хашаажуулж эрүүл ахуйн бүсийг орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор тогтоолгож дэглэмийг мөрдүүлэх. /Шинэчлэн батлагдсан Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын сайд, Байгаль орчин, Ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын хамтарсан А/230-127 дугаар тушаал “Усны сан бүхий газар усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам”
- Төв суурин газрын хүн амын усан хангамжийн худгийн усыг жилд 2-оос доошгүй удаа шинжилгээнд хамруулж үр дүнг аймгийн БОАЖГ болон сав газрын захиргаанд ирүүлж байх, ундны усанд тэнцэхгүй стандартын шаардлага хангахгүй худагт цэнгэгжүүлэгч төхөөрөмж тавих ажлыг төлөвлөж хэрэгжүүлэх.
- Орон нутагт гүн өрмийн худаг гаргадаг мэргэжлийн байгууллага аж ахуйн нэгжүүдэд шинээр худаг гаргахдаа худаг уст цэг гаргах зөвшөөрлийг үндэслэн гаргуулах, гаргасан худагт паспорт нээж аймгийн БОАЖГ-аар баталгаажуулж улсын усны мэдээллийн санд бүртгүүлж ашиглагч болоод сумын Засаг даргын тамгын газарт хүлээлгэж өгдөг журмыг тогтоох. Журмыг зөрчиж худаг уст цэг гаргасан бол хариуцлагыг тухай бүр ноогдуулж байх.
- Хөдөөгийн малчид малын унданд зориулж энгийн уурхайн худаг олноор гаргах болсон нь харьцангуй бэлчээрийн усан хангамж боломжийн түвшинд хүрсэн ч малчид ундны усны шаардлага хангасан гүн өрмийн худаг гаргах байршлыг тогтоохдоо энэ талыг илүүтэй анхаарах.
- Малчид, иргэдэд бэлчээрийн худаг уст цэгийн эзэмшүүлж, худгийн ашиглалт хамгаалалтыг хариуцуулах, хуучин эвдэрсэн худгуудийг сэргээн засварлахад түлхүү анхаарах.
- Усны тоо бүртгэлд хамрагдсан 22 булгаас 2 булгийн эхийг хашиж хамгаалсан байх бөгөөд хашааг сэргээн засварлах шаардлагатай болсон байна. Цаашид үлдсэн булгийг хашиж хамгаалах.



- Ус ашиглагч, хэрэглэгчийн усны эх үүсвэрийн худаг цооногийг бүрэн тоолууржуулж, төлбөр тооцоог тоолуурын заалтыг баримтлан хийж байх.
- Усны тоо бүртгэлийг жил бүр багийн Засаг дарга, БОХУБ, Байгаль хамгаалагч, газрын даамал, хөдөө аж ахуйн мэргэжилтэн, холбогдох төрийн албан хаагчдыг хамруулсан ажлын хэсэг байгуулж 2024 оны тооллогын мэдээлэлд тодотгол хийж тайлагнах ажлыг нэгдсэн удирдлагаар жил бүр зохион байгуулах. Усны тоо бүртгэлийн ажлын хүрээнд бүрдүүлсэн мэдээ, мэдээллийг нэгтгэн боловсруулж, мэдээллийн сангаа шинэчлэн баяжуулж шийдвэр гаргагчид, хэрэглэгчийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн мэдээллээр хангах боломжтой.



Хавсралт 1. Усны тоо бүртгэл явуулах тухай Сүхбаатар аймгийн Засаг даргын захирамж



МОНГОЛ УЛС СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 28 өдөр

Дугаар А/507

Баруун-Урт сум

Уст цэгийн бүртгэл, тооллогын ажлын хэсэг
байгуулах, зардал шийдвэрлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 12 дугаар зүйлийн 12.1.1, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний 100 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд Уст цэгийн бүртгэл, тооллогыг хууль дүрмийн дагуу, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Хэрлэн голын сав газрын захиргаа (Б.Нандинцэцэг), Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргаа (Б.Ялалтбаяр), Буйр нуур, Мэнэнгийн талын сав газрын захиргаа (Ш.Хангарьд), Умард Говийн Гүвээт Халхын дундад талын сав газрын захиргаа (Б.Отгонсүрэн), Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Ш.Нямхүү), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

2. Дээрх зардалд шаардагдах 40,260,500 (дөчин сая хоёр зуун жаран мянга таван зуу) төгрөгийг 2024 онд хэрэгжүүлэх Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Ш.Нямхүү)-т зөвшөөрсүгэй.

3. Уст цэгийн бүртгэл, тооллогын ажлын явц, үр дүнг аймгийн Засаг даргад 2024 оны 4 дүгээр улиралд багтаан танилцуулж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Ш.Нямхүү)-т даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Х.Энхцэцэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.ИДЭРБАТ



Scanned with CamScanner

Хавсралт 2. Усны тоо бүртгэлийн ажил гүйцэтгэх гэрээ



ЗАХИАЛАГЧ: СУХБААТАР АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ДАРГА
Орлон гүйцэтгэгч /Ш.НЯМХҮҮ/ 2024 оны 10 дугаар сарын 01-ны өдөр
12240900/0
TUC6690 8054555

ГҮЙЦЭТГЭГЧ: ХЭРЛЭН ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГА
Б.НАНДИНЦЭЦЭГ/ 2024 оны 10 дугаар сарын 01-ны өдөр
1921100023
UUT1684 4552691

СУХБААТАР АЙМГИЙН МӨНХХААН, СУХБААТАР, ТҮМЭНЦОГТ СУМДАД УСТ ЦЭГИЙН БҮРТГЭЛ, ТООЛЛОГЫН АЖИЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

Дугаар № 02

2024 оны 10 дугаар сарын 01-ний өдөр

Нэг талаас Сүхбаатар аймгийн Байгаль орчны газар (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас Хэрлэн голын сав газрын захиргаа (цаашид "гүйцэтгэгч" гэх) Монгол улсын Иргэний хуулийн 189, 195, 196 дугаар зүйлүүдийн холбогдох заалт, аймгийн Засаг даргын 2024 оны 8 сарын 28-ны өдрийн А/507 тоот захирамжийг удирдлага болгон дараах зүйлийг харилцан тохиролцож 2024 оны 10 сарын 01-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

НЭГ. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1.1 Монгол Улсын Иргэний хууль, Усны тухай хууль тогтоомжийн хүрээнд "Сүхбаатар аймгийн Мөнххаан, Сүхбаатар, Түмэнцогт сумдад уст цэгийн бүртгэл, тооллогын ажил зохион байгуулах" ажил гүйцэтгэхтэй холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

1.2 Захиалагч нь Сав газарт хамрагдах "Сүхбаатар аймгийн Мөнххаан, Сүхбаатар, Түмэнцогт сумдад уст цэгийн бүртгэл, тооллогын ажил зохион байгуулах" ажлыг (цаашид "ажил" гэх) 7,563,500 (Долоон сая таван зуун жаран гурван мянга таван зуун төгрөг)-өөр санхүүжүүлнэ.

1.2. Гүйцэтгэгч нь "Сүхбаатар аймгийн Мөнххаан, Сүхбаатар, Түмэнцогт сумдад уст цэгийн бүртгэл, тооллогын ажил зохион байгуулах" ажлыг 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдөр эхэлж, 2024 оны 10 дугаар сарын 25-ны дотор ажлыг гүйцэтгэсэн байна.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ГОЛ НӨХЦӨЛ

2.1. Захиалагч нь Монгол Улсын Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалтыг хэрэгжүүлэх, сав газрын хамтын үйл ажиллагааг дэмжих зорилгоор Сав газарт хамрагдах "Сүхбаатар аймгийн Мөнххаан, Сүхбаатар, Түмэнцогт сумдад уст цэгийн бүртгэл, тооллогын ажил зохион байгуулах" ажлыг хамтран зохион байгуулж уг ажилд шаардлагатай төсвийг санхүүжүүлнэ.



2.2. Гүйцэтгэгч нь ажлыг холбогдох заавар журмын дагуу гүйцэтгэн, улсын усны мэдээллийн санд оруулах, ажлын тайланг дэлгэрэнгүй бичиж, зурган болон хүснэгтэн мэдээллийг өмнөх тооллогын дүнтэй харьцуулан ирүүлэх, орон нутагтай зөвшилцөн зарим шаардлагатай усны сан бүхий газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад авах үндэслэл, зураглал, CD, .shp файл зэргийг захиалагчид хүлээлгэн өгч орон нутгийн удирдлагуудад танилцуулна.

ГУРАВ. ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ

3.1. Гүйцэтгэгч нь "Сүхбаатар аймгийн Мөнххаан, Сүхбаатар, Түмэнцогт сумдад уст цэгийн бүртгэл, тооллогын ажил зохион байгуулах" ажлыг зохион байгуулахдаа сумдын оролцоог ханган ажиллах, сумдыг мэдээллээр хангах зэрэг ажлыг зохион байгуулж ажиллана.

3.1.1. Усны сан бүхий газрууд /булаг, нуур, гол, рашаан, тойром, шанд/-ын мэдээллийг тус тусд нь бүртгэх, газар дээр нь хэмжилт хийх, хашиж хамгаалах булгийн судалгаа гаргах, шинээр булаг, шанд бүртгэх, зураглал хийх.

3.1.2. Усан хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг шинэчлэн тогтоох.

3.1.3. Хамгаалалтын бүсийг тогтоосны дараа мэдээллийг усны мэдээллийн дэд санд бүртгэх.

3.1.4. Сумдын усан хангамжийн эх үүсвэрийн тэжээгдлийн мужид байрлах ашиглалтгүй цооногийн судалгаа гарган, бүртгэлжүүлэх.

3.1.5. Ус ашиглах эрхийн зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй гаргасан худгийн судалгаа гарган бүртгэлжүүлэх, худгийн ангилал, төрлөөр бүртгэн усны мэдээллийн дэд санд оруулах.

3.1.6. Ашигладаг болон ашигладаггүй худгийн дэлгэрэнгүй судалгааг гаргаж бүртгэл мэдээллийг мэдээллийн санд оруулах.

3.1.7. Тайлан, мэдээллийг холбогдох газруудад хүлээлгэн өгөх /тайланг сум тус бүрээр усан сан бүхий газрын хамгаалалтын бүс тогтоосон зураглалыг .shp файлаар болон CD-нд буулгаж, фото зураг хавсаргасан байдлаар цаасан болон цахимаар өгнө.

ДӨРӨВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. "Сүхбаатар аймгийн Мөнххаан, Сүхбаатар, Түмэнцогт сумдад уст цэгийн бүртгэл, тооллогын ажил зохион байгуулах" ажлын санхүүжилтийг гүйцэтгэгч талын Төрийн сан дах Хэрлэн голын сав газрын захиргааны 100180013403 тоот харилцах дансанд санхүүжилтийн нэхэмжлэхийн дагуу шилжүүлнэ.

4.2. Дээрх ажилд хяналт тавин ажиллана.

4.3. Тайланг хүлээн авч гэрээг дүгнэн акт үйлдэнэ.

ТАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

5.1. Гүйцэтгэгч нь санхүүжилт орж ирснээс хойш бэлтгэл ажлыг ханган гэрээнд заасан хугацаанд чанартай хийж гүйцэтгэнэ.

5.2. Гүйцэтгэх ажлын бүрэлдэхүүнд захиалагч байгууллагын төлөөлөл болон байгаль хамгаалагч, газрын даамал нарыг оролцуулна.

5.3. Ажил гүйцэтгэх бүрэлдэхүүний ажиллаж байгаа унаа машины шатахуун, хөдөлмөрийн аюулгүй байдлаа бүрэн хариуцна.



ЗУРГАА. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА, САНХҮҮЖИЛТ

6.1. Гүйцэтгэгч нь "Сүхбаатар аймгийн Мөнххаан, Сүхбаатар, Түмэнцогт сумдад уст цэгийн бүртгэл, тооллогын ажил зохион байгуулах" ажлыг 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдрөөс эхэлж, 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл хугацаанд гүйцэтгэн, хүлээлгэн өгнө.

6.2. Захиалагч нь гэрээний үнийн дүнг урьдчилгаа 70% гэрээ байгуулсны дараа, ажил гүйцэтгэсэн тайланг үндэслэн үлдэгдэл санхүүжилт 30%-ийг олгоно.

ДОЛОО. ХАРИУЦЛАГА

7.1. Талууд байгаль цаг уурын болон гадны давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүссэн нөхцөл байдлыг харгалзан зайлшгүй тохиолдолд гэрээний хугацааг сунгаж болох бөгөөд бичгээр гэрээний сунгалтыг хийж, гарын үсэг зурж баталгаажсанаар хүчин төгөлдөр болно.

НАЙМ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

8.1. Гэрээтэй холбоотой аливаа маргааныг талууд харилцан тохиролцох замаар шийдвэрлэнэ.

8.2. Талууд тохиролцоонд хүрч чадаагүй бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу маргааныг шүүхэд тавьж шийдвэрлүүлнэ.

ЕС. БУСАД ЗҮЙЛ

9.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

9.2. Гэрээг 2 хувь үйлдэж, 1 хувийг гүйцэтгэгч, 1 хувийг захиалагч тал хадгална.

9.3. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

СҮХБААТАР АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ
ГАЗРЫН УСНЫ НӨӨЦИЙН АШИГЛАЛТ,
ХАМГААЛАЛТ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

 /П.БОЛОРТУНГАЛАГ/

ЗАХИАЛАГЧИЙН ХАЯГ: СҮХБААТАР
АЙМАГ, БАРУУН-УРТ ХОТ, DG-TOWER-7
ДАВХАР.

УТАС/ФАКСЫН ДУГААР: 70518892

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ХЭРЛЭН ГОЛЫН САВ ГАЗРЫН
ЗАХИРГААНЫ МЭРГЭЖИЛТЭН

 /М.САЙНБАЯР/

ЗАХИАЛАГЧИЙН ХАЯГ: ХЭНТИЙ АЙМАГ,
ХЭРЛЭН СУМ, БУЛАГ 2 ДУГААР БАГ,
ТЭМҮҮЖИН Н-13, 1 ДҮГЭЭР ДАВХАР.

УТАС/ФАКСЫН ДУГААР: 70563696



Хавсралт 3. Хэрлэн голын сав газрын захиргааны даргын баталсан ажлын удирдамж



**ХЭРЛЭН ГОЛЫН САВ ГАЗАРТ ХАМААРАХ СҮХБААТАР АЙМГИЙН
СУМДАД УСНЫ ТОО БҮРТГЭЛИЙН ХЭЭРИЙН АЖЛЫГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ**

2024.10.14

Чингис хот

НЭГ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ҮНДЭСЛЭЛ

Усны тухай хуулийн 7.3, 17.1.4, 18.1.5 дахь заалт Сүхбаатар аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Хэрлэн голын сав газрын захиргааны хооронд 2024 оны 10 дугаар сарын 01-ны өдөр байгуулсан гэрээг тус тус үндэслэн Хэрлэн голын сав газарт хамаарах Сүхбаатар аймгийн сумдад усны тоо бүртгэлийн ажлыг зохион байгуулна.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ:

Сүхбаатар аймгийн Мөнххаан, Сүхбаатар, Түмэнцогт сумдууд хамрагдана.

ГУРАВ. АЖЛЫН ХЭСЭГ, ОРОЛЦОГЧ ТАЛУУД:

Усны тоо бүртгэлийн ажлыг гүйцэтгэн зохион байгуулах ажлын хэсэг дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Ч.Сайнбаяр Хэрлэн голын сав газрын захиргааны Газарзүйн мэдээлэл, усны мэдээллийн дэд сан хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: У.Жамбалдагва Хэрлэн голын сав газрын захиргааны Газрын доорх усны нөөц, ашиглалт хариуцсан мэргэжилтэн

Д.Баярхүү Хэрлэн голын СГЗ-ын нярав, жолооч

Сумдын хамгаалагч Багийн дарга нар, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, Байгаль хамгаалагч, Газрын даамал, Бэлчээр усжуулалт хариуцсан мэргэжилтэн, Ус судлалын харуулын ажилтан гэх мэт

ДӨРӨВ. ГҮЙЦЭТГЭХ АЖЛУУД

1. Усны сан бүхий газрууд /булаг, нуур, гол, рашаан, тойром, шанд/ -ын мэдээллийг тус тусад нь бүртгэх, газар дээр нь хэмжилт хийх, хашиж хамгаалах булгийн судалгаа гаргах, шинээр булаг, шанд бүртгэх зураглал хийх.
2. Усан хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг шинэчлэн тогтоох.
3. Хамгаалалтын бүсийг тогтоосны дараа мэдээллийг усны мэдээллийн дэд санд бүртгэх.



Хавсралт 4. Мөнххаан сумын уст цэгийн тоо бүртгэлийн дүн

МӨНХХААН СУМ ХУДГИЙН БҮРТГЭЛИЙН ХҮСНЭГТ

№	Худгийн төрөл	Байршлын солбицол						Н, м	Эзэмшигчийн нэр
1	Гар худаг	47°	20'	15.17"	112°	10'	48.98"	1073.8	Баатарцогт
2	Өрөмдмөл	47°	13'	53.08"	112°	17'	52.64"	1216.6	Г.Азбилэг
3	Гар худаг	47°	14'	7.19"	112°	17'	48.40"	1210.8	нийтийнх
4	Гар худаг	47°	14'	21.11"	112°	17'	59.62"	1204.5	нийтийнх
5	Гар худаг	47°	14'	49.63"	112°	21'	3.37"	1142.6	нийтийнх
6	Гар худаг	47°	16'	43.14"	112°	20'	54.46"	1117.9	Эрхэмбаяр
7	Гар худаг	47°	16'	51.94"	112°	23'	3.76"	1128.3	Эрхэмбат
8	Гар худаг	47°	17'	39.07"	112°	26'	42.28"	1109.3	Батнайрамдал
9	Гар худаг	47°	17'	33.63"	112°	29'	14.01"	1168	Баатархуяг
10	Гар худаг	47°	17'	40.69"	112°	29'	14.13"	1165.9	Баторших
11	Өрөмдмөл	47°	18'	15.36"	112°	30'	19.92"	1138.8	Алтанхуяг
12	Гар худаг	47°	18'	42.13"	112°	37'	52.12"	1179.4	нийтийнх
13	Гар худаг	47°	19'	1.74"	112°	39'	21.40"	1184.4	Батхуяг
14	Гар худаг	47°	19'	2.32"	112°	39'	54.39"	1194	Мягмарсүрэн
15	Гар худаг	47°	20'	34.70"	112°	36'	29.44"	1141.3	Энхбаяр
16	Өрөмдмөл	47°	22'	33.67"	112°	40'	52.77"	1103.1	
17	Өрөмдмөл	47°	18'	38.18"	112°	46'	43.33"	1221.7	П.Энхтөр
18	Өрөмдмөл	47°	19'	23.93"	112°	50'	7.68"	1134.5	Батсүх
19	Өрөмдмөл	47°	15'	29.35"	112°	49'	23.70"	1156.5	Ариунзаяа
20	Өрөмдмөл	47°	15'	21.72"	112°	49'	31.04"	1161	Хунт өгөөж
21	Гар худаг	47°	20'	14.92"	112°	46'	30.45"	1206	Хайдав
22	Өрөмдмөл	47°	21'	49.03"	112°	48'	54.00"	1123	Гантөмөр
23	Өрөмдмөл	47°	20'	57.65"	112°	48'	47.95"	1148	Энхтөр
24	Гар худаг	47°	23'	34.92"	112°	47'	55.91"	1110.7	Ганбат
25	Өрөмдмөл	47°	29'	5.38"	112°	41'	45.31"	1071	
26	Өрөмдмөл	47°	32'	20.13"	112°	51'	44.80"	1018.8	Билэгдэмбэрэл
27	Өрөмдмөл	47°	33'	42.92"	112°	48'	48.43"	1026.3	Х.Дамба
28	Гар худаг	47°	35'	44.16"	112°	48'	30.74"	1015.7	Дамба
29	Гар худаг	47°	36'	47.46"	112°	53'	26.50"	967	Бүжин
30	Өрөмдмөл	47°	36'	44.93"	112°	52'	7.14"	976	нийтийнх
31	Гар худаг	47°	36'	29.48"	112°	55'	58.18"	961.3	нийтийнх
32	Гар худаг	47°	33'	28.22"	112°	55'	32.48"	982.8	Лувсанжамц
33	Өрөмдмөл	47°	33'	20.51"	112°	58'	53.93"	995	Шарав
34	Өрөмдмөл	47°	27'	3.49"	112°	58'	36.23"	1034.8	Лувсанжамц
35	Гар худаг	47°	25'	31.44"	112°	53'	19.97"	1037.3	Ганбат
36	Өрөмдмөл	47°	24'	3.24"	112°	54'	9.23"	1046.3	Хашхүү
37	Гар худаг	47°	23'	36.56"	112°	53'	53.92"	1048.5	нийтийнх
38	Гар худаг	47°	21'	59.26"	112°	53'	42.80"	1055.8	Батнасан

ХЭРЛЭН ГОЛЫН САВ



ГАЗРЫН ЗАХИРГАА

39	Гар худаг	47°	20'	4.87"	112°	55'	45.46"	1077.4	Түвшинтөр
40	Гар худаг	47°	22'	17.50"	112°	59'	14.00"	1085.6	Эрдэнэбат
41	Өрөмдмөл	47°	19'	40.81"	112°	54'	51.25"	1070.2	Эрдэнбаяр
42	Гар худаг	47°	14'	6.10"	112°	56'	0.98"	1136.3	Баатарцогт
43	Гар худаг	47°	13'	5.07"	112°	57'	12.40"	1154.4	Баатарсүх
44	Гар худаг	47°	12'	47.90"	112°	17'	34.90"	1273.7	малчид
45	Өрөмдмөл	47°	14'	7.20"	112°	17'	48.80"	1211.1	малчид
46	Өрөмдмөл	47°	12'	49.80"	112°	22'	30.90"	1163.1	малчид
47	Өрөмдмөл	47°	17'	32.47"	112°	11'	30.16"	1114.4	Баттөмөр
48	Өрөмдмөл	47°	19'	25.45"	112°	11'	24.52"	1094.7	Батжаргал
49	Гар худаг	47°	8'	53.80"	112°	3'	10.00"	1249.8	нийтийнх
50	Гар худаг	47°	8'	56.90"	112°	3'	10.40"	1253.4	нийтийнх
51	Гар худаг	47°	10'	14.80"	112°	2'	12.10"	1205.4	нийтийнх
52	Гар худаг	47°	10'	21.90"	112°	1'	27.30"	1191	нийтийнх
53	Гар худаг	47°	10'	36.60"	112°	0'	58.00"	1174.8	нийтийнх
54	Гар худаг	47°	10'	9.90"	112°	0'	37.50"	1183.6	нийтийнх
55	Гар худаг	47°	4'	53.70"	112°	0'	36.70"	1303.1	малчид
56	Гар худаг	47°	6'	43.20"	112°	0'	18.70"	1289.9	малчид
57	Гар худаг	47°	8'	53.80"	112°	3'	10.00"	1249.8	малчид
58	Гар худаг	47°	8'	56.90"	112°	3'	10.40"	1253.4	малчид
59	Гар худаг	47°	10'	14.80"	112°	2'	12.10"	1205.4	малчид
60	Өрөмдмөл	47°	10'	21.90"	112°	1'	27.30"	1191	малчид
61	Гар худаг	47°	10'	36.60"	112°	0'	58.00"	1174.8	малчид
62	Гар худаг	47°	10'	9.90"	112°	0'	37.50"	1183.6	малчид
63	Гар худаг	47°	4'	31.80"	111°	58'	38.38"	1257.7	нийтийнх
64	Гар худаг	47°	5'	13.15"	111°	59'	48.28"	1251.4	Б.Лхагвадорж
65	Өрөмдмөл	47°	6'	12.09"	111°	55'	4.03"	1153.7	Ч.Дамдинсүрэн
66	Өрөмдмөл	47°	5'	4.54"	111°	52'	20.43"	1132.8	Ч.Очирбат
67	Өрөмдмөл	47°	8'	31.26"	111°	53'	45.85"	1128	Б.Хүрэлчулуун
68	Гар худаг	47°	9'	28.63"	111°	57'	24.82"	1154.1	Х.Баянмөнх
69	Гар худаг	47°	9'	27.09"	111°	57'	30.83"	1154.3	Х.Баянмөнх
70	Өрөмдмөл	47°	11'	44.42"	111°	58'	31.95"	1127.3	А.Баттулга
71	Гар худаг	47°	12'	17.90"	111°	58'	45.78"	1123	Д.Түвшинбаяр
72	Өрөмдмөл	47°	12'	45.63"	111°	56'	17.55"	1100.7	Н.Мэндамар
73	Гар худаг	47°	12'	46.57"	111°	56'	4.72"	1098.5	Н.Мэндамар
74	Гар худаг	47°	12'	56.72"	111°	54'	9.39"	1079.1	Э.Рэнцэнбаяр
75	Гар худаг	47°	15'	50.44"	111°	52'	11.18"	1055.1	Н.Гэрэлт од
76	Гар худаг	47°	15'	48.63"	111°	51'	52.30"	1058.2	Н.Гэрэлт од
77	Гар худаг	47°	18'	39.74"	111°	50'	58.43"	1053.2	Ө.Эрдэнэхүү
78	Өрөмдмөл	47°	17'	40.29"	111°	49'	5.65"	1085.1	Г.Ангараг
79	Өрөмдмөл	47°	18'	42.33"	111°	52'	38.06"	1048.1	Я.Гомбодорж
80	Гар худаг	47°	17'	51.28"	111°	53'	13.97"	1052.3	Х.Наранцогт
81	Өрөмдмөл	47°	16'	35.35"	111°	55'	44.89"	1079	Ч.Намжилдорж
82	Гар худаг	47°	15'	29.06"	111°	56'	36.42"	1085.8	Д.Болд

ХЭРЛЭН ГОЛЫН САВ



ГАЗРЫН ЗАХИРГАА

83	Өрөмдмөл	47°	15'	23.96"	111°	59'	58.10"	1113.4	Амгаланбаатар
84	Өрөмдмөл	47°	13'	54.10"	112°	0'	58.29"	1182.7	А.Батдэлгэр
85	Гар худаг	47°	17'	54.97"	111°	59'	51.17"	1169.9	Д.Дэмбэрэлдорж
86	Өрөмдмөл	47°	20'	26.79"	111°	59'	49.04"	1143.5	Гэрэлт-Од
87	Өрөмдмөл	47°	22'	38.45"	111°	58'	0.26"	1125.9	М.Галбадрах
88	Өрөмдмөл	47°	21'	10.11"	111°	53'	59.87"	1056.9	Д.Энхбаатар
89	Өрөмдмөл	47°	19'	59.43"	111°	52'	50.90"	1043.1	П.Баярхүү
90	Гар худаг	47°	21'	19.57"	111°	52'	45.79"	1038.7	Д.Амгалан
91	Гар худаг	47°	22'	56.04"	111°	52'	36.63"	1031.3	Чулуунбаатар
92	Гар худаг	47°	23'	0.00"	111°	52'	35.73"	1031.9	Чинзориг
93	Гар худаг	47°	21'	15.78"	111°	47'	51.59"	1073.8	нийтийнх
94	Өрөмдмөл	47°	20'	50.27"	111°	47'	0.31"	1069.2	Б.Бат эрдэнэ
95	Өрөмдмөл	47°	20'	16.13"	111°	45'	16.49"	1085.2	нийтийнх
96	Өрөмдмөл	47°	18'	48.48"	111°	46'	24.53"	1095.6	А.Амарсанаа
97	Өрөмдмөл	47°	19'	39.41"	111°	42'	36.44"	1124.4	
98	Өрөмдмөл	47°	15'	16.14"	111°	44'	1.54"	1159.9	Д.Батболд
99	Гар худаг	47°	15'	22.46"	111°	40'	31.36"	1204.4	Дэлгэрдалай
100	Өрөмдмөл	47°	15'	38.72"	111°	38'	57.28"	1176.8	Э.Баярбат
101	Өрөмдмөл	47°	16'	47.42"	111°	37'	16.58"	1159.6	Ж.Соёлоо
102	Өрөмдмөл	47°	15'	40.63"	111°	36'	14.22"	1142.3	Ж.Батсайхан
103	Гар худаг	47°	13'	37.19"	111°	37'	0.09"	1166.3	нийтийнх
104	Гар худаг	47°	12'	59.86"	111°	44'	34.75"	1128.6	Ж.Хүрэл
105	Гар худаг	47°	13'	12.27"	111°	46'	36.59"	1095.6	Р.Доржжовд
106	Гар худаг	47°	15'	39.68"	111°	49'	40.61"	1080.6	Б.Сүхтоогоо
107	Гар худаг	47°	8'	36.83"	111°	49'	37.15"	1086.8	Д.Ундармаа
108	Гар худаг	47°	6'	7.37"	111°	49'	10.70"	1100.7	Д.Тогоосүрэн
109	Гар худаг	47°	5'	11.90"	111°	49'	1.97"	1110.2	Н.Батбаатар
110	Гар худаг	47°	4'	8.38"	111°	49'	24.71"	1114.2	А.Батбүян
111	Гар худаг	47°	4'	0.24"	111°	49'	20.74"	1114.7	нийтийнх
112	Гар худаг	47°	2'	20.80"	111°	56'	15.79"	1216.6	Тогоосүрэн
113	Гар худаг	46°	55'	24.99"	111°	53'	21.02"	1311.7	Б.Анхбаяр
114	Гар худаг	46°	54'	13.88"	111°	52'	20.35"	1260.3	Ч.Гантөмөр
115	Гар худаг	46°	57'	9.82"	111°	51'	9.33"	1270.4	Ю.Балдан-Ойдов
116	Гар худаг	46°	58'	1.50"	111°	49'	58.07"	1221.7	Ю.Балдан-Ойдов
117	Өрөмдмөл	46°	58'	55.78"	111°	47'	46.01"	1174	Ю.Балдан-Ойдов
118	Гар худаг	46°	57'	9.12"	111°	47'	18.74"	1185.5	С.Түмэнбаяр
119	Өрөмдмөл	46°	56'	30.15"	111°	45'	57.44"	1185.2	Ш.Содномцэрэн
120	Өрөмдмөл	46°	59'	29.57"	111°	43'	3.93"	1177.7	П.Бүнчин
121	Өрөмдмөл	47°	1'	11.94"	111°	42'	41.17"	1175.1	П.Нүрзэд
122	Гар худаг	47°	0'	59.77"	111°	38'	1.12"	1244.4	Г.Ууганбат
123	Гар худаг	47°	5'	13.50"	111°	59'	48.80"	1252.3	малчид
124	Гар худаг	46°	54'	13.00"	111°	52'	20.80"	1260.7	малчид
125	Өрөмдмөл	46°	56'	30.50"	111°	45'	57.90"	1185.4	Чимэд
126	Гар худаг	47°	7'	14.22"	111°	35'	28.99"	1190.2	Л.Доржпүрэв

ХЭРЛЭН ГОЛЫН САВ



ГАЗРЫН ЗАХИРГАА

127	Гар худаг	47°	7'	30.27"	111°	36'	17.39"	1206.7	Л.Доржпүрэв
128	Гар худаг	47°	5'	51.96"	111°	38'	23.21"	1245.7	М.Нямбаяр
129	Гар худаг	47°	5'	31.11"	111°	40'	26.70"	1205.1	Б.Одсүрэн
130	Гар худаг	47°	5'	31.68"	111°	40'	29.20"	1203.5	М.Манлайбаяр
131	Өрөмдмөл	47°	5'	10.64"	111°	41'	50.75"	1179.6	Д.Энхтайван
132	Гар худаг	47°	5'	11.27"	111°	42'	39.91"	1170.2	Б.Энхтайван
133	Гар худаг	47°	2'	55.21"	111°	48'	27.02"	1122	Ц.Угтахбаяр
134	Гар худаг	47°	2'	21.06"	111°	56'	16.12"	1216.8	Т.Батбаяр
135	Өрөмдмөл	47°	1'	51.67"	111°	57'	52.28"	1258.3	Б.Төмөрболд
136	Гар худаг	47°	1'	46.87"	111°	58'	1.73"	1267.7	С.Ганболд
137	Гар худаг	47°	1'	0.81"	111°	58'	35.49"	1304.3	Б.Амартүвшин
138	Гар худаг	46°	59'	48.29"	111°	34'	47.22"	1249.1	Ч.Амарсанаа
139	Өрөмдмөл	46°	59'	55.30"	111°	33'	19.20"	1231.4	Б.Гэрэлчулуун
140	Гар худаг	46°	58'	52.55"	111°	32'	33.00"	1213	А.Дамба
141	Гар худаг	46°	56'	57.82"	111°	28'	5.44"	1159.9	Н.Тулга
142	Гар худаг	46°	56'	46.62"	111°	26'	13.30"	1158.4	
143	Гар худаг	46°	59'	54.78"	111°	30'	15.73"	1197.4	Д.Батаа
144	Өрөмдмөл	47°	2'	5.85"	111°	29'	39.58"	1204.2	Г.Ууганбат
145	Өрөмдмөл	47°	5'	57.32"	111°	33'	32.85"	1214.8	А.Мөнхдорж
146	Өрөмдмөл	47°	25'	6.60"	112°	48'	31.70"	1099.2	
147	Өрөмдмөл	47°	26'	7.60"	112°	48'	32.30"	1091.4	
148	Өрөмдмөл	47°	35'	56.90"	112°	49'	32.50"	997	Ганболд
149	Өрөмдмөл	47°	33'	0.80"	112°	44'	46.80"	1089.2	Батцэнгэл
150	Өрөмдмөл	47°	32'	11.00"	112°	42'	14.40"	1106.7	
151	Гар худаг	48°	23'	46.00"	112°	53'	32.00"	924.7	Л.Гүрсоронзон
152	Өрөмдмөл	47°	30'	22.00"	113°	0'	11.80"	1074.9	
153	Өрөмдмөл	47°	30'	22.00"	113°	0'	10.60"	1074.5	Дагвасүрэн
154	Өрөмдмөл	47°	27'	29.60"	112°	53'	33.80"	1027.9	Доржсамбуу
155	Өрөмдмөл	47°	1'	52.50"	111°	58'	10.50"	1277.5	Б.Сайханбилэг
156	Өрөмдмөл	47°	2'	31.40"	111°	48'	20.60"	1125.3	Г.Цогтбаатар
157	Өрөмдмөл	47°	5'	58.40"	111°	49'	5.70"	1105.2	Мөнхцэцэг
158	Өрөмдмөл	47°	17'	44.40"	111°	46'	55.70"	1109.5	Б.Баатарчулуун
159	Өрөмдмөл	47°	22'	30.20"	111°	49'	44.50"	1087	Б.Нямдорж
160	Өрөмдмөл	47°	19'	13.00"	112°	3'	3.30"	1198.3	Д.Эрдэнэбат
161	Гар худаг	47°	29'	35.91"	112°	53'	23.91"	979	нийтийн
162	Гар худаг	47°	28'	53.45"	112°	57'	44.60"		нийтийн
163	Өрөмдмөл	47°	12'	56.76"	111°	36'	37.89"	1175	Чинболд
164	Өрөмдмөл	47°	12'	7.08"	111°	34'	45.43"	1188	Чинболд
165	Өрөмдмөл	47°	8'	33.38"	111°	32'	51.53"	1154	Б.Эрдэнэсүх
166	Өрөмдмөл	47°	20'	19.70"	112°	41'	54.90"	1173	Г.Эрдэнэбилэг
167	Өрөмдмөл	47°	22'	56.30"	112°	45'	33.20"	1125	Б.Баттөмөр
168	Өрөмдмөл	47°	26'	7.60"	112°	48'	32.60"	1097	Бямбасүрэн
169	Өрөмдмөл	47°	23'	6.10"	112°	48'	30.80"	1094	Нийтийн
170	Өрөмдмөл	47°	29'	12.30"	112°	51'	23.10"	1039	Мэндбаатар

ХЭРЛЭН ГОЛЫН САВ



ГАЗРЫН ЗАХИРГАА

171	Өрөмдмөл	47°	30'	33.00"	112°	53'	40.80"	1015	Хишигбаатар
172	Өрөмдмөл	47°	27'	29.70"	112°	53'	33.60"	1022	Төрөө
173	Өрөмдмөл	47°	24'	3.40"	112°	54'	8.80"	1040	Нийтийн
174	Өрөмдмөл	47°	24'	36.70"	112°	53'	53.80"	1039	
175	Өрөмдмөл	47°	25'	28.40"	112°	52'	23.50"	1041	Г.Хишигээ
176	Өрөмдмөл	47°	31'	7.20"	113°	4'	28.10"	1066.7	Мэндбаатар

МӨНХХААН СУМ НУУРЫН БҮРТГЭЛИЙН ХҮСНЭГТ

№	Нуур, тойрмын нэр	Байршлын солбицол							Устай эсэх төлөв (2020 онд)	Устай эсэх төлөв (2024 онд)
1	Тосонгийн тойром	47°	18'	42.68"	111°	51'	37.03"	1050.4	Устай	Устай
2	Эрдэнэ уул	47°	16'	11.45"	111°	52'	55.53"	1062.4	Устай	Устай
3	Цээлийн нуур	47°	8'	43.22"	111°	47'	52.53"	1099.6	Устай	Устай
4	Цагаан нуур	47°	1'	0.80"	111°	52'	27.60"	1241	Устай	Устай

МӨНХХААН СУМ БУЛГИЙН БҮРТГЭЛИЙН ХҮСНЭГТ

№	Булгийн нэр	Байршлын солбицол						Н, м	Устай эсэх төлөв (2020 онд)	Устай эсэх төлөв (2024 онд)
1	Наран булаг	47°	26'	20.486	112°	47'	43.31	1115.7	Устай	Устай
2	Баян хааны хоолой	47°	35'	28.172	112°	55'	49.166	969.4	Устай	Устай
3	Хутан булаг	47°	30'	9.317	113°	4'	34.72	1088.4	Устай	Устай
4	Заан ширээтийн ар булаг	47°	12'	14.018	111°	38'	34.062	1199.6	Устай	Устай
5	Хөндлөнгийн булаг	47°	9'	26.107	111°	42'	3.236	1153.2	Устай	Устай
6	Зүрхийн хоолойн булаг	47°	26'	47.2	112°	55'	26.7	1084.7	Устай	Устай
7	Заан ширээтийн баруун булаг	47°	10'	53.9	111°	37'	48.7	1214.2	Устай	Устай
8	Хажуу худгийн булаг	47°	17'	25	112°	22'	15	1094.7	Усгүй	Устай
9	Баруун булаг	47°	2'	7.3	111°	56'	44.6	1260	Усгүй	Устай



Хавсралт 5. Түмэнцогт сумын уст цэгийн тоо бүртгэлийн дүн

ТҮМЭНЦОГТ СУМ ХУДГИЙН БҮРТГЭЛИЙН ХҮСНЭГТ

№	Худгийн төрөл	БАЙРШЛЫН СОЛБИЦОЛ							Эзэмшигчийн нэр
1	Өрөмдмөл	47°	31'	4.81"	112°	21'	19.78"	990.8	С.Номуун
2	Гар худаг	47°	30'	11.13"	112°	24'	4.37"	1017.5	Ц.Бямбажав
3	Гар худаг	47°	29'	36.90"	112°	26'	59.91"	999.7	С.Төмөр-очир
4	Өрөмдмөл	47°	29'	47.93"	112°	27'	34.77"	994.5	С.Төмөр-очир
5	Өрөмдмөл	47°	30'	8.10"	112°	28'	54.15"	981.8	Ц.Ооёо
6	Гар худаг	47°	28'	41.22"	112°	29'	38.61"	995.6	Энхтөр
7	Өрөмдмөл	47°	26'	24.33"	112°	30'	3.15"	1022.1	Б.Анхбаяр
8	Өрөмдмөл	47°	26'	22.47"	112°	30'	6.60"	1024.9	Нямдорж
9	Гар худаг	47°	25'	47.45"	112°	33'	22.95"	1057.1	Н.Батжаргал
10	Гар худаг	47°	24'	23.75"	112°	29'	38.90"	1051.2	Д.Энхтөгс
11	Гар худаг	47°	23'	19.25"	112°	21'	53.52"	1034.2	Ш.Дамдинсүрэн
12	Гар худаг	47°	24'	2.79"	112°	23'	19.79"	1039.1	Б.Лхагвасүрэн
13	Өрөмдмөл	47°	23'	44.57"	112°	19'	33.88"	1028.2	Д.Баярхүү
14	Гар худаг	47°	24'	46.16"	112°	20'	15.53"	1022.5	Цэнд аюуш
15	Өрөмдмөл	47°	26'	35.49"	112°	27'	34.14"	1054.2	С.Батцэнгэл
16	Өрөмдмөл	47°	26'	18.58"	112°	22'	0.11"	1026	Амарбаатар
17	Гар худаг	47°	28'	19.38"	112°	21'	15.45"	1004.1	Х.Доржготов
18	Гар худаг	47°	30'	15.16"	112°	18'	29.24"	1002	А.Сүхбаатар
19	Гар худаг	47°	27'	50.35"	112°	15'	59.39"	1032.9	Ж.Гангаа
20	Гар худаг	47°	28'	10.07"	112°	16'	49.97"	1024.7	Г.Марууш
21	Өрөмдмөл	47°	28'	26.96"	112°	17'	23.27"	1020.3	Г.Марууш
22	Өрөмдмөл	47°	27'	59.49"	112°	18'	25.58"	1016.9	А.Оч гэрэл
23	Гар худаг	47°	28'	5.74"	112°	20'	34.62"	1002.5	Ж.Ариунболд
24	Гар худаг	47°	26'	20.80"	112°	17'	26.34"	1023.9	Д.Лхагвадорж
25	Гар худаг	47°	25'	32.52"	112°	14'	48.52"	1037.2	Л.Сүхбаатар
26	Гар худаг	47°	24'	14.96"	112°	15'	3.38"	1034	Д.Баярхүү
27	Гар худаг	47°	23'	45.82"	112°	15'	40.87"	1036.5	Г.Бор
28	Өрөмдмөл	47°	23'	28.08"	112°	18'	24.24"	1050.3	Д.Баярхүү
29	Гар худаг	47°	20'	51.91"	112°	17'	50.89"	1075.6	Д.Мөнхбат
30	Гар худаг	47°	21'	22.36"	112°	13'	41.24"	1061.6	Б.Ганбаатар
31	Гар худаг	47°	22'	42.85"	112°	14'	0.47"	1047.3	Г.Бор
32	Гар худаг	47°	22'	24.72"	112°	13'	40.70"	1051.7	Г.Бор
33	Өрөмдмөл	47°	23'	35.43"	112°	11'	36.00"	1060	Т.Энхбат
34	Өрөмдмөл	47°	22'	53.45"	112°	10'	14.43"	1069.3	Т.Энхбат
35	Гар худаг	47°	20'	59.47"	112°	11'	21.54"	1071.5	Б.Ганболд
36	Гар худаг	47°	20'	55.65"	112°	8'	43.97"	1090.6	Элбэгжаргал
37	Гар худаг	47°	23'	31.51"	112°	6'	34.96"	1092.7	Ганчулуун
38	Гар худаг	47°	25'	55.33"	112°	4'	6.11"	1145.5	Ш.Цогт эрдэнэ

ХЭРЛЭН ГОЛЫН САВ



ГАЗРЫН ЗАХИРГАА

39	Гар худаг	47°	26′	12.39″	112°	4′	55.21″	1149.4	Д.Нэргүй
40	Өрөмдмөл	47°	25′	25.96″	112°	6′	7.73″	1126.4	Б.Эрдэнэсүх
41	Өрөмдмөл	47°	25′	21.29″	112°	9′	44.54″	1095.1	Д.Лүндэгдорж
42	Гар худаг	47°	27′	8.49″	112°	11′	29.21″	1079.5	Т.Энхбат
43	Гар худаг	47°	31′	20.32″	112°	11′	29.95″	1069.7	Б.Батбаяр
44	Гар худаг	47°	34′	2.05″	112°	11′	57.86″	1047.2	Д.Энхбат
45	Гар худаг	47°	34′	1.47″	112°	11′	58.78″	1047.3	Э.Мөнх эрдэнэ
46	Гар худаг	47°	30′	31.98″	112°	9′	43.69″	1124.4	О.Чулуунбаатар
47	Гар худаг	47°	31′	31.06″	112°	8′	13.28″	1132.7	Б.Хатанбаатар
48	Өрөмдмөл	47°	31′	31.54″	112°	8′	10.12″	1132.3	Б.Хатанбаатар
49	Өрөмдмөл	47°	32′	9.72″	112°	6′	57.69″	1163.1	Г.Мөнхжаргал
50	Өрөмдмөл	47°	33′	38.33″	112°	9′	16.57″	1115.2	Монгол жүюаньли ХХК
51	Гар худаг	47°	33′	38.10″	112°	9′	12.26″	1117.1	
52	Өрөмдмөл	47°	33′	38.47″	112°	8′	43.41″	1143.9	Монгол жүюаньли ХХК
53	Өрөмдмөл	47°	34′	54.29″	112°	10′	50.51″	1064.5	Ч.Сайнбаяр
54	Өрөмдмөл	47°	34′	46.70″	112°	7′	43.09″	1108.7	Д.Энхбат
55	Гар худаг	47°	36′	37.05″	112°	10′	56.49″	1120.7	Х.Эрхэмбаяр
56	Гар худаг	47°	36′	39.24″	112°	10′	53.63″	1120.6	Ч.Бадарч
57	Гар худаг	47°	32′	8.09″	112°	16′	3.96″	1017.5	Д.Нэргүй
58	Өрөмдмөл	47°	31′	43.06″	112°	16′	32.01″	1011	Д.Энхтүвшин
59	Гар худаг	47°	31′	27.04″	112°	16′	56.97″	1009.9	Б.Сүхтоогоо
60	Гар худаг	47°	31′	38.89″	112°	18′	6.98″	1006.3	Б.Сүхтоогоо
61	Гар худаг	47°	33′	13.99″	112°	17′	50.12″	1008	Ц.Лувсангомбо
62	Гар худаг	47°	32′	44.91″	112°	20′	16.57″	979.5	С.Түмэндэмбэрэл
63	Өрөмдмөл	47°	34′	2.89″	112°	20′	31.69″	987	У.Эрдэнэдулам
64	Өрөмдмөл	47°	34′	3.80″	112°	20′	6.75″	996	Даваадорж
65	Гар худаг	47°	39′	59.90″	112°	13′	24.11″	1063	Бишбиш
66	Гар худаг	47°	40′	1.81″	112°	13′	16.04″	1067.6	Бишбиш
67	Гар худаг	47°	41′	0.99″	112°	15′	42.27″	1013.1	Ж.Ганбат
68	Гар худаг	47°	41′	49.55″	112°	18′	23.97″	979	Г.Шинийн нэгэн
69	Гар худаг	47°	42′	8.62″	112°	21′	48.79″	971	Д.Отгонбаяр
70	Гар худаг	47°	44′	3.60″	112°	21′	20.65″	1014	Д.Ганхуяг
71	Гар худаг	47°	47′	30.31″	112°	23′	12.29″	894	Д.Эрдэнэ
72	Гар худаг	47°	47′	30.28″	112°	23′	12.26″	894	Д.Эрдэнэ
73	Гар худаг	47°	45′	32.73″	112°	23′	36.70″	932.9	Түмэнцогт ОНӨҮГ
74	Гар худаг	47°	43′	48.58″	112°	25′	11.62″	915.1	Бор
